Оюутнуудын “Эрүүл Мэндийн Цагаан Толгойн” мэдлэгийн үнэлгээ

Г.Ганцэцэг[1], С.Наранчимэг[1], С.Нармандах[1], Д.Солонго[2]

[1]АШУҮИС, Био-Анагаахын Сургууль
[2]АШУҮИС, Сувилахуйн сургууль
Цахим шуудан: gantsetseg07@gmail.com, Утас: 99281112

Түлхүүр үг:
Эрүүл мэндийн цагаан толгой
Анагаахын оюутан

Товч утга:
Үндэслэл: Одоо үед хүмүүс эрүүл мэнддээ анхаарал хандуулах нь ихэссэн, хэрхэн анхаарал хандуулах, яаж энэ талаарх мэдлээгээ дээшлүүлэхээ талаарх мэдлэг дутуугаас, төр засаг, нийгмийн эрүүл мэндийн бодлого учир дутагдалтай байгаа нь эрүүл мэндийн боловсрол олж авах хүртээмжийг багасгаж байна. **Зорилго:** Анагаахын чиглэлээр суралцаж буй оюутнуудын эрүүл мэндийн цагаан толгойн мэдлэгийг үнэлэхэд оршино. **Арга, аргчлал:** Судалгаанд АШУҮИС-ийн анагаах ухаан, уламжлалт анагаах, шим судлал, био-анагаах, эдийн засгийн эрүүл мэнд, эрүүл мэндийн нийгмийн ажилтны ангийн 18-24 насны 532 оюутныг хамруулсан. **Үр дүн:** Анагаахын сургуулийн оюутнуудын эрүүл мэндийн цагаан толгойн мэдлэгийг үнэлэхэд хангалттай хэмжээнд байв. **Дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан оюутнууд эрүүл мэндийн цагаан толгойн мэдлэгийг цахим сүлжээгээр авахад хялбар байдаг, дийлэнх нь өвдсөн үедээ хаана хандахаа мэддэг, өөрийн эрүүл мэндийн асуудалд эмчээс зөвлөгөө авдаг, сэтгэл санаа, ухамсраа эрүүл байлгахад ямар зүйл хийхээ сайн мэддэг байна.

Үндэслэл: Эрүүл мэндийн цагаан толгой *(Health literacy)* хэмээх нэр томъёо нь хүн бүр эрүүл мэндийнхээ төлөө зөв шийдвэр гаргах, шаардлагатай мэдлэг мэдээллээр хангагдах, эрүүл аж төрөх нөхцөл бололцоогоор хангагдах цогц үйл ажиллагаа юм.[1] Анх 1974 онд “Эрүүл мэндийн боловсрол”-ын бага хурлын үеэр хэлэлцэж, түүнээс хойш *“Health Literacy”*-ын тодорхойлолт, хэмжилтийн талаар одоог хүртэл сонирхож, өргөн хүрээнд авч хэлэлцсээр байна.[2] Эрүүл мэндийн цагаан толгойг сайтар эзэмшсэнээр өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг шинжилгээнд хамрагдах, эрүүл мэндийн үйлчилгээгээ зөв цагт нь авах, нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулахад оролцох зэрэг өөрийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд тусалдаг байна.[3]

Эрдэмтэн Floyd, Mimms & Yelding Howard нар “хүн эрүүл байна гэдэг нь бие махбодын хувьд төдийгүй сэтгэц, ухамсар, сэтгэл хөдлөл, сэтгэлгээ, оюун санаа, амьдарч буй нийгэм, соёлын хувьд анхаарал хандуулахаас гадна хөдөлмөр эрхлэлтийн байдал ч эрүүл мэндэд шууд нөлөөлдөг“ болохыг дурдсан.[4] Өнөө үед хүмүүс эрүүл мэнддээ анхаарал хандуулах нь багассан, хэрхэн анхаарал хандуулах, яаж энэ талаарх мэдлэгээ дээшлүүлэх талаар мэдлэг дутмаг, төр засаг, нийгмийн эрүүл мэндийн бодлого учир дутагдалтай явагдсаар байгаа нь эрүүл мэндийн боловсрол муутай болгоход нөлөөлж байна.

Эрүүл мэндийн байгууллагад ажилладаг эмнэлгийн мэргэжилтний ажлын үүрэг, хариуцлага өргөн цар хүрээгээр өөрчлөгдөж, тэдний бие даасан тусламж нь хүн ам илүү төвлөрсөн хөдөө орон нутаг, цэцэрлэг, сургууль, албан газарт үгүйлэгдэж байна. Анагаахын чиглэлээр суралцаж буй оюутнуудын эрүүл мэндийн цагаан толгойн мэдлэгт одоогоор үнэлгээ хийгдээгүй тул бид энэхүү сэдвийг сонгосон болно.

Зорилго: Анагаахын чиглэлээр суралцаж буй оюутнуудын эрүүл мэндийн цагаан толгойн мэдлэгийг үнэлэхэд оршино.

Зорилт:

1. Судалгаанд хамрагдсан оюутнуудын “Эрүүл мэндийн цагаан толгой”-н талаар мэдлэгийг үнэлэх.
2. Оюутнуудад эрүүл мэндийн асуудал тохиолдсон үед авах арга хэмжээ, шийдвэр гаргах чадварыг тодорхойлох

Арга, аргачлал: Судалгааг дескрептив судалгааны асуумжийн аргыг ашиглан хийж, 2021 оны 1-2-р сард хийж гүйцэтгэсэн. Судалгаанд АШУҮИС-ийн анагаах ухаан, уламжлалт анагаах ухаан, шим судлал, био-анагаах, эдийн засгийн эрүүл мэнд, эрүүл мэндийн нийгмийн ажилтны ангид суралцаж байгаа 18-24 насны 532 оюутныг хамруулан, google form ашиглан судалгааг авсан. Оюутны эрүүл мэндийн цагаан толгойн талаарх мэдлэгийг (Health Literacy) үнэлэхийн тулд асуулгыг Европын Холбооны Консорциумаас 2012 онд баталсан 3 бүлэг, нийт 47 асуултаас бүрдсэн асуулгын хуудсыг (HLS-EU-Q47) орчуулан, үүнээс 16 асуулгыг сонгосон ба асуулга нь үндсэн 2 хэсгээс бүрдэх ба эхний хэсэгт оролцогчдын ерөнхий мэдээлэл, хоёрдугаар хэсэгт 16 асуулга бүхий эрүүл мэндийн боловсролыг тодорхойлох асуултыг оруулж, ликертийн хэмжүүрээр *(likert questions)* тодорхойлсон. Статистик боловсруулалтыг SPSS 22 программыг ашигласан ба бүлэг хоорондын ялгааг стюдентийн T тестээр, хүчин зүйлийн ялгааг Хи квадрат-аар шалгаж, хүчин зүйл хоорондын хамаарлыг шугаман болон ложистик регрессийн аргаар тодорхойлж судалгааны үр дүнд тусгав.

Үр дүн: Судалгаанд хамрагдагсдын насны байдлыг авч үзвэл 17 настай оролцогч 40 (7.5%), 18 настай 412 (77.4%), 19 настай 58 (10.9%), 20 настай 6 (1.1%), 21 настай 6 (1.1%), 22-оос дээш настай оюутан 10 (1.9%) байв. Хүйсийн хувьд эмэгтэй 466 (81.3%) эрэгтэй оюутан 107 (18.7%) байна. Хөдөө орон нутгаас 278 (48.5%), хотоос элссэн 239 (41.7%), бусад газар төгссөн 56 (9.8%) оюутан байна.

Судалгаанд оролцсон оюутнууд эрүүл мэндийн цагаан толгойн мэдлэгийг цахим сүлжээгээр дамжуулан 264 (49.6%) нь маш хялбар, 219 (41.2%) нь хялбар, 29 (5.5%) нь мэдэхгүй, 19 (3.6%) нь хүндрэлтэй, 1 (0.2%) нь маш хүндрэлтэй ($p<0.002$) гэж хариулжээ. Өвдсөн үедээ хаана хандахаа хялбархан мэддэг гэж 221 (41.5%) нь, хялбархан мэддэг 267 (50.2%), мэдэхгүй гэж 30 (5.6%) нь хүндрэлтэй гэж 14 (2.6%) нь хариулжээ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд оролцогсдын ерөнхий мэдээлэл (хувиар)

Үзүүлэлтүүд	Тоо /n/	Хувь /%/
Нийт оролцогчид	532	100
- Эрэгтэй	101	81
- Эмэгтэй	431	19
Нас		
- 17 нас	40	7.5
- 18 нас	412	77.4
- 19 нас	58	10.9
- 20 нас	6	1.1
- 21 нас	6	1.1
- 22 наснаас дээш	10	1.9
ЕБС-ийг хаана дүүргэсэн байдал		
- Хот	229	43
- Хөдөө	298	56
- Гадаад	5	0.9
ЕБС-ийн хэлбэр		
- Улсын	439	82.5
- Хувийн	93	17.5

Судалгаанд оролцсон оюутнууд эрүүл мэндийн цагаан толгойн мэдлэгийг хангалттай (>19 оноо) ба хангалтгүй (<18) хэмээн ангилж үзэхэд оюутнуудын хүйс, амьдралын нөхцөл, ерөнхий боловсролын байдал, байршил зэрэгт статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Оюутны мэдлэг хангалттай ба хангалтгүй 2 бүлэгт ерөнхий үзүүлэлтүүдийн ялгаатай байдал

	<18 n /%/ 452 /84.96/	>19 n /%/ 80 /15.04/	Нийт n /%/ 532 /100/	P value
Эрэгтэй Эмэгтэй	86/19.0/ 366/81.0/	15/18.8/ 65/81.2/	101/19.0/ 431/81.0/	0.954
Хот Хөдөө Гадаад	190/42.0/ 259/57.3/ 3/0.7/	39/48.8/ 39/48.8/ 2/2.5/	289/56.0/ 229/43.0/ 5/0.9/	0.133
Орон сууц Оюутны байр Гэр хороолол Бусад	306/76.7/ 72/15.9/ 52/11.5/ 22/4.9/	52/67.0/ 15/18.8/ 11/13.8/ 2/2.5/	358/67.3/ 87/16.4/ 63/11.8/ 24/4.5/	0.674
Хувийн Улсын	74/16.4/ 378/83.6/	19/23.8/ 61/76.3/	93/17.5/ 439/82.5/	0.109
Нийт оноо	61.67±10.67	58.37±15.36	61.18±11.54 /min-0, max-80/	0.001

Судалгаанд оролцогчдын төгссөн сургуулийн нөхцөл, амьдарлын нөхцлөөр авч үзэхэд асуумжийн нийт онооны хувьд статистикийн ач холбогдолтойгоор ялгаатай ($p<0.0001$, $p<0.0001$) байв. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Оюутнуудын төгссөн сургууль, амьдралын нөхцөл

	Судалгаанд хамрагдагсдын тоо n/%/ 532 /100/	Нийт оноо 61.18±11.54 /min-0, max-80/	P value
Хүйс			0.258
- Эмэгтэй	431/81.1/	61.45±10.69	
- Эрэгтэй	101/18.9/	60.00±14.63	
Төгссөн сургууль			0.397
- Улсын	439/82.5/	61.38±11.44	
- Хувийн	93/17.5/	60.22±12.02	
Амьдардаг газар			<0.0001
- Орон сууц	358 /67.29/	61.80±10.46	
- Гэр хороолол	63 /11.84/	63.71±8.67	
- Дотуур байр	87 /16.35/	56.52±16.34	
- Бусад	24 /4.52/	62.12±8.24	
Хаана сургууль төгссөн			<0.0001
- Хот	229/18.8/	60.98±11.31	
- Хөдөө	298/81.1/	61.71±10.62	
- Гадаад	5/1/	38.20±36.32	

Өөрийн эрүүл мэндийн байдалд үндэслэн шийдвэр гаргахдаа эмчээс зөвлөгөө авахад маш хялбар гэж 242 (45.5%), хялбар гэж 266 (50%), мэдэхгүй гэж 18 (3.4%) хүндрэлтэй гэж 6 (1.1%) нь хариулжээ. Сэтгэл санаа, ухамсраа эрүүл байлгахад юу хийхээ сайн мэддэг гэж 264 (49.6%), мэддэг 219 (41.2%), мэдэхгүй 29 (5.5%), мэдэхэд хүндрэлтэй гэж 20 (3.8%) нь хариулжээ.

Хэлцэмж: Судлаач Borhani F, Alhani F, Mohammadi E (2010) нар эрүүл мэндийн мэдлэг (Health Literacy) нь хүн амын эрүүл мэндэд нөлөөлдөг чухал хүчин зүйл юм. Эрүүл мэндийн цагаан толгойн түвшин багатай хүмүүс нь мэдлэг дутмаг, өөртөө үзүүлэх тусламж үйлчилгээний чадвар хангалтгүй байдаг гэж тодорхойлжээ.[3] Харин бидний судалгаанд оролцогсод эрүүл мэндийн цагаан толгойн мэдлэгийг цахим сүлжээгээр дамжуулан авахдаа 29 (5.5%) нь мэдэхгүй, 19 (3.6%) нь хүндрэлтэй, 1 (0.2%) нь маш хүндрэлтэй ($p<0.002$) гэж хариулсан байна. Хятадын судлаач Hu X. (2009) нарын “Hu Bei мужийн иргэдийн эрүүл мэндийн мэдлэг, эрүүл байхад нөлөөлөх нь” гэсэн судалгаанд иргэд өөрийнхөө эрүүл мэндийг сайн гэж үнэлсэн, харин эрүүл мэндийн мэдлэгийн түвшин нь доогуур байжээ.[5] Энэ нь бидний хийсэн судалгаанд: иргэд өөрийнхөө эрүүл мэндийн байдалд хийсэн үнэлгээнээс үзэхэд: хамгийн олон буюу нийт хариултын 54.2 % нь сайн гэсэн хариулсан нь манай судалгаанд хамрагдсан оюутнуудын сэтгэл санаа, ухамсраа эрүүл байлгахад юу хийхээ сайн мэддэг гэж 264 (49.6%), мэддэг 219 (41.2%), мэдэхгүй 29 (5.5%) гэсэн үр дүнтэй ойролцоо байна.

Дүгнэлт:

1. Бидний судалгаанд хамрагдсан оюутнуудын дийлэнх нь эрүүл мэндийн цагаан толгойн мэдлэгийг цахим сүлжээгээр авдаг ба хэрэв өвдвөл хаана хандахаа мэддэг байна.
2. Судалгаанд хамрагдсан оюутнууд өөрийн эрүүл мэндийн асуудалд эмчээс зөвлөгөө авдаг, сэтгэл санаа, ухамсраа эрүүл байлгахад ямар зүйл хийхээ сайн мэддэг байна.

Ном зүй:

1. *Shum J, Poureslami I, Doyle-Waters MM, FitzGerald JM. The application of health literacy measurement tools (collective or individual domains) in assessing chronic disease management: a systematic review protocol. Syst Rev. 2016 Jun 7;5:97. doi: 10.1186/s13643-016-0267-8. PMID: 27267468; PMCID: PMC4897812.*
2. *Lindsay Clare Kobayashi. Health literacy during ageing and implications for health behaviour. A thesis submitted for the degree of Doctor of Philosophy. 2010.X.14.*
3. *Borhani F, Alhani F, Mohammadi E, Abbaszadeh A. Professional Ethical Competence in nursing: the role of nursing instructors. J Med Ethics Hist Med. 2010;3:3. Published 2010*
4. *Floyd, Mimms & Yelding Howard Personal Health-Perspectives & Lifestyles 2nd Edition. Published 1998;528,24*
5. *Hu, Xiaoyun & Wu, Jianping & Gong, Xun & Xia, Qinghua & Qin, Shilong & Li, Ling & Yu, Siyi & Gan, Tian & Hu, Jian. (2011). The characteristics of health Literacy of residents in hubei province. 1. 10.1109/ITiME.2011.6130888.*

Evaluation of “Knowledge About Health Literacy” in Medical Students

Gantsetseg G[1], Naranchimeg S[1], Narmandakh S[1], Solongo D[2]

[1]MNUMS, School of Biomedicine
[2]MNUMS, School of Nursing
E-mail: gantsetseg07@gmail.com, Tel: +976 99281112

Introduction: Increased attention to health, lack of knowledge on how to care for and how to improve knowledge, and lack of government and public health policies are reducing access to health education.
Objective: To assess the health literacy of medical students.
Materials and Methods: The study involved 532 students aged 18-24 from the School of Medicine, School of Traditional Medicine, School of Biomedicine, Economic Health and Health Social Work at the Academy of Sciences of Mongolia.
Results: It was sufficient to assess the medical alphabet knowledge of medical students.
Conclusion: The surveyed students have easy access to health alphabet information online, most of them know where to turn when they are sick, seek medical advice on their health issues, and know what to do to keep their minds and minds healthy.

Keywords: Health literacy, Medical student